

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2023/17-НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: www.selenge@audit.gov.mn	Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа Утас: 7036-3040 Цахим хаяг: enkhtuyach@audit.gov.mn
Сүхбаатар сум	Аудитын менежер: Б.Батмөнх Утас: 7036-3036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn
2023 он	Ахлах аудитор: Т.Болор Утас: 7036-2442 Цахим хаяг: bolort@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт	3-5
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	6-11
3. Санхүүгийн тайлангийн тодруулга	12-22
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	18
4. Аудитын тайлан	23-26
4.1 Ерөнхий зүйл	23
4.2 Материаллаг байдал	23
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	23
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	24
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	25
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	26
5. Аудитын илрүүлэлт	27-32
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	33-35

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ОНЕО	Орон нутгийн ерөнхий орлого
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХС	Хоршоог хөгжүүлэх сан
ЭБАТ	Эрх бүхий албан тушаалтан
ЭМТ	Эрүүл мэндийн төв



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ШААМАР СУМЫН ЗАСАГ ДАРГА
Ф.СЕРИКБОЛ ТАНАА

2023.03.25 № СЭА-2023/17-НА-СТА-ТТЗ

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-т заасны дагуу Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн нэгтгэсэн үр дүн, нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн мэдэгдэхүйц нөлөөний улмаас Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчлүүд илэрсэн байна. Үүнд:

- Цалингийн нэмэгдэл, урамшууллыг илүү тооцож олгосон,
- Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ-ийн авлага үүсгэсэн,
- Сумын ЗДТГ-ын гадна тохижилтын ажлыг гүйцэтгэж дуусаагүй, ашиглалтад хүлээн аваагүй байхад үлдэгдэл төлбөрийг шилжүүлсэн,

- МҮОНТ-ийн мэдээллийн цагаар хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг бэлтгэж, санхүүжүүлсэн,
- Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан,
- “Эл Эм констракшн” компанитай байгуулсан гэрээний төлбөрийг төвлөрүүлээгүй,
- “Нийтийн ахуй үйлчилгээ, халуун усны барилга”-ыг иргэн Б.Батсүхэд ашиглуулж, ашиглалтын зардлыг төсвөөс төлсөн,
- Жилийн эцэст эд хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй,
- Бараа материалын болон бэлэн мөнгөний орлого зарлагын тайланг гаргаагүй,
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 13 дугаар зүйлийн 13.1, 13.4, 13.7, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, 20.2.6, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь заалтууд болон аймгийн ИТХ-ын 2022 оны 208 дугаар албан бичиг, 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-г тус тус зөрчсөн байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч нь 2022 оны үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөсөн санхүүжилтийг бүрэн төвлөрүүлж, төсвийн гүйцэтгэл 85.3 хувьтай тайлагнагдан, батлагдсан төсвийг 14.7 хувиар хэмнэсэн байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, ЭМТ, соёлын төв нь тус тусын яамдын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд шилжсэнээр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд толилуулж, тодруулснаас бусад аудиторын шийдлээр онцлох асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,161,712.60	938,436.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	289,017.80	411,835.60
33	АВЛАГА	359,713.40	216,071.50
35	БАРАА МАТЕРИАЛ	512,981.40	310,529.50
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	12,676,893.60	4,920,109.70
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12,676,893.60	4,920,109.70
39200	Биет хөрөнгө	12,434,490.10	4,786,501.80
39300	Биет бус хөрөнгө	242,403.60	133,607.90
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	13,838,606.20	5,858,546.30
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	151,432.90	300
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	151,432.90	300
41300	Өглөг	151,432.90	300
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	13,687,173.30	5,858,246.30
51	Засгийн газрын хувь оролцоо	13,687,173.30	5,858,246.30
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,375,458.00	693,139.50
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	0	693,139.50
51200	Хуримтлагдсан үр дүн	5,938,972.00	3,595,249.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,372,743.40	1,569,857.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	13,838,606.20	5,858,546.30

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	5,827,791.80	2,410,036.40
11	ТАТВАРЫН ОРЛОГО	242,615.60	505,883.70
110	Орлогын албан татвар	45,414.50	319,712.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	45,414.50	319,712.50
113	Хөрөнгийн албан татвар	43,398.90	58,585.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	153,802.20	127,585.60
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	708,001.40	375,381.30
120	Нийтлэг татварын бус орлого	708,001.40	375,381.30
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,877,174.80	1,528,771.40
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,527,015.60	1,380,990.60
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,527,015.60	1,380,990.60
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,241,606.70	1,362,782.40
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,890,432.30	508,355.40
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	361,864.20	55,697.50
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	395,767.70	454,883.60
2104	Хангамж, бараа материалын зардал	166,336.30	47,137.70
2105	Нормативт зардал	469,743.00	200
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	87,714.60	78,488.00
2107	Томилолт, зочны зардал	3,691.00	3,402.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	102,943.30	43,621.20
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	763,114.40	170,996.60
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	285,408.80	18,208.10
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	300,776.20	1,029,045.80
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	83,870.00	8,854,487.60
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	216,906.20	-7,825,441.80

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,470,755.00	0.00	13,470,755.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-487.90	0.00	-487.90
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	13,470,267.10	0.00	13,470,267.10
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	216,906.20	0.00	216,906.20
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	13,687,173.30	0.00	13,687,173.30
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	13,687,173.30	0.00	13,687,173.30
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,010,354.00	0.00	-1,010,354.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	12,676,819.30	0.00	12,676,819.30
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	-7,825,441.80	0.00	-7,825,441.80
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	5,858,246.30	0.00	5,858,246.30

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	6,549,385.00	2,223,344.00
11	ТАТВАРЫН ОРЛОГО	242,615.60	505,883.70
110	Орлогын албан татвар	45,414.50	319,712.50
1100	Хувь хүний орлогын албан татвар	45,414.50	319,712.50
113	Хөрөнгийн албан татвар	43,398.90	58,585.70
118	Бусад татвар, төлбөр, хураамж	153,802.20	127,585.60
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	21,962.90	65,643.30
1181	Газрын төлбөр	4,544.00	59,337.00
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	127,295.30	2,605.20
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	143,935.20	208,726.80
120	Нийтлэг татварын бус орлого	143,935.20	208,726.80
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	6,162,834.20	1,508,733.40
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	6,074,425.10	1,480,904.30
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,074,425.10	1,480,904.30
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,511,134.70	1,459,865.30
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,859,027.80	540,987.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	363,634.20	68,295.30
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	398,819.70	508,883.60
2104	Хангамж, бараа материалын зардал	94,319.30	56,788.30
2105	Нормативт зардал	461,065.70	200
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	90,795.20	100,263.60
2107	Томилот, зочны зардал	3,691.00	3,670.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	92,251.20	60,737.50
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,530.50	120,038.90
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,563,290.40	21,039.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	474,960.00	742,439.60
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	156,277.40	607,621.90
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	156,277.40	607,621.90
2200	Дотоод эх үүсвэрээр	156,277.40	607,621.90
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-156,277.40	-607,621.90
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-84,000.00	-12,000.00
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	84,000.00	12,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	234,682.60	122,817.80
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	54,335.20	289,017.80
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	289,017.80	411,835.60

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Дүн	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,862,098.60	1,588,934.52	273,164.08	85.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,414,954.90	1,339,717.82	75,237.08	94.68
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,394,211.00	1,321,409.70	72,801.30	94.78
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	554,310.20	540,987.58	13,322.62	97.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	70,725.40	68,295.29	2,430.11	96.56
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	555,736.30	504,072.49	51,663.81	90.70
2104	Хангамж, бараа материалын зардал	50,228.70	46,907.40	3,321.30	93.39
2105	Нормативт зардал	258.80	200.00	58.80	77.28
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	88,947.30	88,523.45	423.85	99.52
2107	Томилолт, зочны зардал	3,786.40	3,670.50	115.90	96.94
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	53,704.40	52,687.49	1,016.91	98.11
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	16,513.50	16,065.50	448.00	97.29
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	20,743.90	18,308.12	2,435.78	88.26
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	378,548.50	237,216.70	141,331.80	62.66
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	68,595.20	12,000.00	56,595.20	17.49
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,862,098.60	1,665,535.98	196,562.62	89.44
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,768,790.70	1,591,687.06	177,103.64	89.99
320001	Орон нутгийн төсвөөс	1,641,339.90	1,464,236.26	177,103.64	89.21
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	127,450.80	127,450.80	0.00	100.00
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	93,307.90	73,848.92	19,458.98	79.15
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	77,800.00	73,848.92	3,951.08	94.92
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	15,507.90	0.00	15,507.90	0.00
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	18,238.85	-18,238.85	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	92,109.48	-92,109.48	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	196.00	126.00	70.00	64.29
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	4.00	4.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	96.00	61.00	35.00	63.54
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	96.00	61.00	35.00	63.54
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	15.00	15.00	0.00	100.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	73.00	38.00	35.00	52.05
650010	Гэрээт ажилтан	2.00	2.00	0.00	100.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	6.00	6.00	0.00	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		529,727.40
21	УРСГАЛ ЗАРДАЛ		168,748.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		147,881.60
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		4,811.10
2104	Хангамж, бараа материалын зардал		9,880.90
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		21,166.20
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		8,050.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		103,973.40
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		20,866.50
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		360,979.20
221001	Их засвар		263,179.20
222001	Тоног төхөөрөмж		97,800.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		529,727.40
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		16,072.80
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		486,718.60
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		26,936.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Сэлэнгэ аймгийн Шаамар сумын төсвийн төвлөрүүлэн захирагч /цаашид Шаамар сумын ТТЗ гэх/ нь “Хамтарч шийдье, хөгжин дэвшье” гэсэн эрхэм зорилгын хүрээнд үйл ажиллагаа явуулсан бөгөөд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, сурталчлах, биелэлтийг нь хангах ажлыг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах үндсэн дээр хүн амын хүнсний аюулгүй байдлыг хангах, мал сүргийг өсгөн үржүүлэх, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах, мал эмнэлэг, үржлийн ажлыг зохион байгуулах, байгалийн гэнэтийн аюул, мал, амьтан, ургамлын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг бүрэн эрхийнхээ хүрээнд авч хэрэгжүүлэх,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, хөтөлбөр, төсөл зохиох, зохицуулах, хяналт шинжилгээ хийх, үнэлж дүгнэх, бодлогын удирдамжаар хангах,
- Харьяалах нутаг дэвсгэрийнхээ болон засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж хоорондын, түүнчлэн бүс нутгийн чанартай үйлдвэрлэл, үйлчилгээ, нийгэм-соёлын зориулалттай барилга байгууламж барьж байгуулахад орон нутгийн болон хувийн хөрөнгө оруулалт хийх ажлыг дэмжиж, зохион байгуулах,
- Төрийн ажилтныг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн хэтийн зорилт болон жилийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөл, гүйцэтгэлийн тайлан, орон нутгийн төсвийн болон түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлуулахаар тухайн ИТХ-д оруулах, батлагдсан хөтөлбөр, төсөв, төслийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Нутаг дэвсгэрийнхээ татварын албыг удирдлагаар хангах, татварын орлогыг хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн дагуу төвлөрүүлэх, шилжүүлэх ажлыг зохион байгуулах,
- Төрийн болон тухайн орон нутгийн өмчийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомж, ИТХ-ын шийдвэрийн биелэлтийг хангах ажлыг зохион байгуулах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, тогтоомж, бодлого журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,

- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдсөн,
- Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдсөн,
- Төрийн албаны тухай хуульд 2022 оны 04 дүгээр сарын 22, 07 дугаар сарын 05, 11 дугаар сарын 11-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн 107 дугаар тогтоолоор төрийн үйлчилгээний албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- Засгийн газрын 2022 оны 194 дүгээр тогтоолоор “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт”-д өөрчлөлт оруулсан,
- ХХААХҮС-ын 2021 оны А/361 дугаар тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам” хэрэгжиж эхэлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилтийн үр нөлөө сул гэж үзлээ.

Шаамар сумын ТТЗ-ийн санхүүгийн үйл ажиллагаанд тайлант онд хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Шаамар сумын ТТЗ нь аймгийн Засаг даргын 2021 оны А/58 дугаар захирамжаар баталсан аймгийн ТЕЗ-ийн багцад хамаарах төсөвт байгууллагуудад, сумдын төрийн сангийн үйл ажиллагаанд мөрдөх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүү, бүртгэлийн үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

Дээрх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 7,980,059.9 мянган төгрөгөөр буюу 57.7 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	289,017.8	411,835.6	122,817.8
Авлага	359,713.4	216,071.5	-143,641.9
Бараа материал	512,981.4	310,529.5	-202,451.9
Үндсэн хөрөнгө	12,676,893.6	4,920,109.7	-7,756,783.9
Нийт хөрөнгө	13,838,606.2	5,858,546.3	-7,980,059.9
Өр төлбөр	151,432.9	300.0	-151,132.9
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	13,687,173.3	5,858,246.3	-7,828,927.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	13,838,606.2	5,858,546.3	-7,980,059.9

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр засгийн газрын хувь оролцоо дансуудыг дор тус бүрээр нь тайлбарлан харуулсан болно.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 411,835.6 мянган төгрөг болж, өмнөх оноос 122,817.8 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	289,017.8	411,835.6	122,817.8
Төгрөг	289,017.8	411,835.6	122,817.8
Төрийн сангийн харилцах	289,017.8	411,835.6	122,817.8
Дүн	289,017.8	411,835.6	122,817.8

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэлд тайлагнагдсан 319,726.1 мянган төгрөг ОНХО-ын дансанд, 44,241.4 мянган төгрөг ОНХС-ийн дансанд, 47,868.1 мянган төгрөг ХХС-ийн дансанд тус тус байршиж байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 216,071.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 143,641.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	2,004.40	886.8	-1,117.6
Төлбөртэй үйлчилгээний авлага	130,438.10	-	-130,438.1
Зээлийн хүүгийн авлага	12,367.80	12,119.7	-248.1
Байгууллагаас авах авлага	-	4.1	4.1
Хувь хүмүүст олгосон зээл	214,903.10	203,060.9	-11,842.2
Дүн	359,713.4	216,071.5	-143,641.9

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын данс буурсан нь ЭМДС-аас авах 130,438.1 мянган төгрөгийн /Шаамар сумын ЭМТ-ийн 21,904.6 мянган төгрөгийн, Дулаанхаан тосгоны ЭМТ-ийн 108,533.5 мянган төгрөгийн/ төлбөртэй үйлчилгээний авлагыг тайлант онд хүлээн авч эдгээр байгууллага эь ЭМЯ-ны харьяанд шилжсэнээс шалтгаалсан байна.

Авлага дансны эцсийн үлдэгдэлд дараах авлагууд тайлагнагдсан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ-ын 4.1 мянган төгрөг, ИТХ-ын 886.8 мянган төгрөгийн НДШ-ийн авлага,
- ХХС-ийн зээлийн 203,060.9 мянган төгрөг, зээлийн хүүгийн 12,119.7 мянган төгрөгийн авлага.

Авлагын дансны үлдэгдэлд хугацаа хэтэрсэн 97,548.5 мянган төгрөгийн дараах авлагууд байна. Үүнд:

- ХХС-ийн зээлийн хүүгийн 8,436.6 мянган төгрөгийн авлага,
- ХХС-ийн зээлийн 89,111.9 мянган төгрөгийн авлага байна.

Тайлант онд хугацаа хэтэрсэн /2011-2019 оны хооронд зээл авсан/ 286,414.3 мянган төгрөгийн зээл, зээлийн хүүгийн авлагаас 64 зээлдэгчийн 188,865.8 мянган төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

3.4.3 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 310,529.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 202,451.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	47,851.1	0.0	-47,851.1
Бэлэн бүтээгдэхүүн	47,855.1	0.0	-47,855.1
Хангамжийн материал	414,632.9	310,529.5	-104,103.4
Бичиг хэргийн материал	14,503.7	2,434.6	-12,069.1
Аж ахуйн материал	242,700.2	284,561.1	41,860.9
Сэлбэг хэрэгсэл	8,864.1	3,269.6	-5,594.5
Түлш, шатах тослох материал	7,692.0	0.0	-7,692.0
Барилгын засварын материал	17,251.9	1,770.0	-15,481.9
Хүнсний материал	3,125.4	0.0	-3,125.4
Бусад хангамжийн материал	120,495.6	18,494.2	-102,001.4
Мал амьтад	2,642.3	0.0	-2,642.3
Дүн	512,981.4	310,529.5	-202,451.9

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь тайлант онд 428,217.9 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авсан, Дэлхийн зөн ОУБ-аас 500.0 мянган төгрөгийн зурагт хуудас хүлээн авсан болон 158,966.3 мянган төгрөгийн бараа материалыг зарцуулсан, тус төвлөрүүлэн захирагчийн тайланд нэгтгэгддэг байсан сум, тосгоны боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагууд нь тайлант онд тус тусын яамдын харьяанд шилжсэнтэй холбоотойгоор 9 байгууллагын 448,008.4 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлснээс шалтгаалсан байна.

3.4.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл /анхны өртгөөр/ 6,027,895.1 мянган төгрөг болж, өмнөх оноос 8,673,457.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	11,214,217.8	3,471,117.0	-7,743,100.8
Авто-тээврийн хэрэгсэл	393,258.3	385,395.0	-7,863.3
Машин тоног төхөөрөмж (компьютер)	818,864.8	144,106.6	-674,758.2
Тавилга, аж ахуйн эд хогшил	304,854.4	73,310.9	-231,543.5
Зам, гүүрийн байгууламж	268,501.0	325,612.1	57,111.1
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	6,035.0	0.0	-6,035.0
Бусад үндсэн хөрөнгө	1,391,970.8	1,493,145.5	101,174.7
Ном	57,010.5	0.0	-57,010.5
Программ хангамж	13,769.0	5,088.0	-8,681.0
Бусад биет бус хөрөнгө	232,871.4	130,120.0	-102,751.4
Дүн	14,701,353.0	6,027,895.1	-8,673,457.9

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд дараах өөрчлөлтүүд гарсан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ, ИТХ-ын төсвийн хөрөнгөөр худалдан авсан 23,050.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, тавилга эд хогшил,
- Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 97,808,2 мянган төгрөгийн сум, тосгоны зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг,
- Аймгийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 97,800.0 мянган төгрөгийн бохирын машин, хогийн пункер,
- Сумын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 89,209.5 мянган төгрөгийн хогийн машин, дэд станц барих, агаарын шугам,
- Сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 143,000.0 мянган төгрөгийн түрээсийн хүлэмж,
- Дэлхийн зөн ОУБ-аас 49,986.8 мянган төгрөгийн гүний худаг, тоног төхөөрөмж, аймгийн БОАЖГ-аас 31,650.0 мянган төгрөгийн мотоцикл, био жорлон хандиваар хүлээн авсан,
- Аймгийн ИТХ-ын 2009 оны 151 дүгээр тогтоол, 2021 оны 96 дугаар тогтоолуудаар Дулаанхаан тосгоны Захирагчийн албанд бүртгэлтэй 16,551.9 мянган төгрөгийн 2 тээврийн хэрэгслийг акталж, данс бүртгэлээс хассан,
- Бүтцийн өөрчлөлтөөр 9,232,429.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг сум, тосгоны боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудад шилжүүлсэн,
- Аймгийн ОНӨГ-ын даргын 2022 оны 533 дугаар тушаалаар Дулаанхаан тосгоны Захирагчийн албанд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн боловч цаашид ашиглах боломжтой 7,289.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй хөрөнгийн ашиглах хугацааг сунгаж, 6,358.0 мянган төгрөгөөр үнийг шинэчлэн тогтоож, данс бүртгэлд тусгаснаас шалтгаалсан байна.

3.4.5 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 300.0 мянган төгрөг болж, өмнөх оноос 151,132.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 6. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	/ мянган төгрөгөөр /	
		Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	400.0	300.0	-100.0
Байгууллагад төлөх өглөг	151,032.9	-	-151,032.9
Дүн	151,432.9	300.0	-151,132.9

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Энэ нь сум, тосгоны ЭМТ нь өмнөх онд үүссэн ЭМДС-аас авах татаас санхүүжилтийн авлагыг бүрэн хүлээн авч, бусад байгууллагад төлөх өглөгийг барагдуулсан, эдгээр байгууллага нь ЭМЯ-ны харьяалалд шилжсэнээс шалтгаалсан байна.

3.4.6 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 5,858,246.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 7,828,927.0 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Засгийн газрын хувь оролцоо

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,375,458.0	693,139.5	-1,682,318.5
Хуримтлагдсан үр дүн	5,938,972.0	3,595,249.0	-2,343,723.0
Өмнөх үеийн үр дүн	5,722,065.7	11,420,690.8	5,698,625.1
Тайлант үеийн үр дүн	216,906.3	-7,825,441.8	-8,042,348.1
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,372,743.3	1,569,857.8	-3,802,885.5
Дүн	13,687,173.3	5,858,246.3	-7,828,927.0

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл буурсан нь сум, тосгоны боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудыг тайлант онд бүтцийн өөрчлөлтөөр улсын төсвийн байгууллага болгож, шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт:

Сумын ИТХ-ын “Шаамар сумын 2022 оны тодотгосон төсөв батлах тухай” 61 дүгээр тогтоолоор тайлант онд 457,528.7 мянган төгрөгийн татварын орлого, 84.800.0 мянган төгрөгийн татварын бус орлого, нийт **542,328.7** мянган төгрөгийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр **665,337.6** мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 22.7 хувиар давуулан биелүүлсэн байна.

Хүснэгт № 8. Төвлөрүүлэх орлого

/мянган төгрөг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Татварын орлого	457,528.7	505,883.7	48,355.0	110.57
Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого	220,000.0	277,532.7	57,532.7	126.15
Үйл ажиллагааны орлого	20,000.0	14,822.3	-5,177.7	74.11
Хөрөнгийн орлого	17,500.0	15,962.8	-1,537.2	91.22
Хөрөнгө борлуулсны орлого	8,300.0	11,394.7	3,094.7	137.29
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	11,500.0	5,086.7	-6,413.3	44.23
Бууны албан татвар	715.0	790.0	75.0	110.49
Малд ногдуулах албан татвар	-	52,708.9	52,708.9	-
Улсын тэмдэгтийн хураамж	3,000.0	1,763.4	-1,236.6	58.78
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	7,200.0	7,805.7	605.7	108.41
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	6,000.0	5,536.0	-464.0	92.27
Газрын төлбөр	51,818.7	37,421.7	-14,397.0	72.22

Дуудлага худалдаа	110,855.0	72,453.6	-38,401.4	65.36
Ойн нөөц ашигласны төлбөр	-	137.6	137.6	-
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	100.0	477.2	377.2	477.20
Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр	540.0	1,990.4	1,450.4	368.59
Татварын бус орлого	84,800.0	159,453.9	74,653.9	188.04
Торгуулийн орлого	50,000.0	107,785.5	57,785.5	215.57
Төсөвт байгууллагын өөрийн орлого	19,800.0	24,576.0	4,776.0	124.12
Бусад орлого	15,000.0	27,092.4	12,092.4	180.62
Нийт орлогын дүн	542,328.7	665,337.6	123,008.9	122.68

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн орлогын төлөвлөгөө давж биелэхэд Малын тоо толгойн албан татварыг төлөвлөөгүй боловч гүйцэтгэлээр 52,708.9 мянган төгрөг төвлөрсөн, торгуулийн орлого 57,785.5 мянган төгрөгөөр давж биелсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төсвийн орлогод нөлөөлөхүйц хэмжээний давсан болон тасарсан орлогуудын шалтгааныг тодруулбал:

Давж биелсэн орлогууд:

- **Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлого:** Засгийн газрын 2022 оны 107, 192, 194 дүгээр тогтоолуудаар төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбоотойгоор цалин хөлс, шагнал, урамшуулал болон түүнтэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогоос суутган тооцох татварын орлого нэмэгдэж, 57,532.7 мянган төгрөгөөр,
- **Малын тоо толгойн албан татвар:** Малын тоо толгойн албан татварыг орлогын төлөвлөгөөнд тусгаагүй, гүйцэтгэлээр 52,708.9 мянган төгрөгийн орлого төвлөрсөн,
- **Торгуулийн орлого:** Тайлант онд аймгийн Цагдаагийн газрын Замын цагдаагийн тасгаас тус сумын нутаг дэвсгэрт аян зохион байгуулж, ажилласантай холбоотойгоор тус орлого 57,785.5 мянган төгрөгөөр давж биелсэн байна.

Тасарсан орлого:

- **Дуудлага худалдаа:** Тайлант онд 4 удаа дуудлага зохион байгуулсан боловч дуудлага худалдаанд 1 оролцогч ирсэн, дуудлага худалдааны ялагч дуудлага худалдааны үнийг төлөөгүй гэсэн үндэслэлээр 2 удаа хүчингүй болсон,
- **Газрын төлбөр:** Сумын газар эзэмшигч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудын газрын төлбөр төлөлт хангалтгүй байсан зэргээс шалтгаалж, орлого тасарсан байна.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр болон нийт зарлагыг 1,557,822.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 25 дугаар тогтоолоор аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 1,060,195.8 мянган

төгрөг, аймгийн ОНХС-аас олгох шилжүүлгийг 127,450.8 мянган төгрөгөөр тус тус баталсан бол дээрх тогтоолыг үндэслэн сумын ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн 36 дугаар тогтоолоор сумын төсвийн орлогыг 427,528.7 мянган төгрөг, өөрийн орлогыг 19,800.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс санхүүжих 220,425.9 мянган төгрөг, ХХС-ийн зээлийн эргэн төлөлтөөс 58,000.0 мянган төгрөгийг төвлөрүүлэхээр тооцож, эх үүсвэр болон нийт зарлагыг 1,913,401.2 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Аймгийн ИТХ-ын 2022 оны 5 дугаар сарын 11-ны 55 дугаар тогтоолоор аймгийн 2022 оны төсвийг тодотгож, аймгаас олгох санхүүгийн дэмжлэгийг 188,302.6 мянган төгрөгөөр бууруулж баталсантай холбогдуулан сумын сумын ИТХ-ын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 61 дүгээр тогтоолоор дараах төсвийн тодотголыг хийсэн байна. Үүнд:

- Эх үүсвэрийг 137,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж:
 - Дуудлага худалдааны орлогыг 97,000.0 мянган төгрөг,
 - Урьд оны үлдэгдлээс санхүүжих 42,000.0 мянган төгрөг,
 - Бусад орлогыг 12,000.0 мянган төгрөг,
 - Хог хаягдлын хураамжийг 6,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж,
 - Цалин хөлс, шагнал урамшуулал тэдгээртэй адилтгах орлогыг 20,000.0 мянган төгрөгөөр бууруулсан.
- Зарлагыг 51,302.6 мянган төгрөгөөр бууруулж:
 - Сумын ОНХО-ын зардлыг 101,450.0 мянган төгрөгөөр,
 - Сумын ЗДТГ-ын урсгал зардлыг 19,100.1 мянган төгрөгөөр,
 - Сумын ИТХ-ын урсгал зардлыг 3,000.0 мянган төгрөгөөр,
 - Дулаанхаан тосгоны Захирагчийн албаны урсгал зардлыг 3,500.1 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж,
 - Сум, тосгоны боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардлыг 178,352.8 мянган төгрөгөөр бууруулсан.

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 12 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,862,098.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,414,954.9 мянган төгрөгийг урсгал зардалд, 378,548.5 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд, 68,595.2 мянган төгрөгийг ХХС-ийн зээлд зарцуулахаар төлөвлөсөн байна.

Нийт зардлын 871,893.2 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс, 542,328.7 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 127,450.8 мянган төгрөгийг ОНХС-аас, 58,000.0 мянган төгрөгийг ХХС-ийн олгосон зээлийн эргэн төлөлтийн эх үүсвэрээс, урьд оны үлдэгдлээс 262,425.9 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 9. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэлийг байгууллага тус бүрээр харуулбал:

<i>/мянган төгрөгөөр/</i>					
№	Байгууллагын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	88,939.5	85,358.7	3,580.8	95.97

2	Засаг даргын Тамгын газар	713,668.8	591,785.5	121,883.3	82.92
3	Дулаанхаан тосгоны Захирагчийн алба	158,463.0	154,640.3	3,822.7	97.59
4	Орон нутгийн хөгжлийн сан	173,148.5	128,907.2	44,241.3	74.45
5	Сум хөгжүүлэх сан	70,595.2	14,000.0	56,595.2	19.83
6	Шаамар сумын ЕБС	162,244.8	150,990.0	11,254.8	93.06
7	Дулаанхаан тосгоны ЕБС	78,171.2	78,171.1	0.1	100.00
8	Шаамар сумын 1 дүгээр цэцэрлэг	55,534.1	53,641.2	1,892.9	96.59
9	Шаамар сумын 2 дугаар цэцэрлэг	77,493.4	73,363.2	4,130.2	94.67
10	Дулаанхаан тосгоны цэцэрлэг	81,873.3	81,873.2	0.1	100.00
11	Шаамар сумын ЭМТ	60,850.2	40,898.3	19,951.9	67.21
12	Дулаанхаан тосгоны ЭМТ	51,616.6	47,665.3	3,951.3	92.34
13	Шаамар сумын Соёлын төв	53,155.5	52,073.6	1,081.9	97.96
14	Дулаанхаан тосгоны Соёлын төв	36,344.5	35,566.9	777.6	97.86
	Нийт дүн	1,862,098.6	1,588,934.5	273,164.1	85.33

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Гүйцэтгэлээр аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээс 871,893.2 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 592,343.1 мянган төгрөг, ОНХС-аас 127,450.8 мянган төгрөг, ХХС-ийн эх үүсвэрээс 49,272.9 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 24,576.0 мянган төгрөг, нийт **1,665,536.0** мянган төгрөгийн санхүүжилтийг авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,588,934.5 мянган төгрөг буюу 85.3 хувьтай байгаа нь урсгал зардлыг 75,237.1 мянган төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 141,331.8 мянган төгрөгөөр, эргэж төлөгдөх зээлийг 56,595.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Урсгал зардлын гүйцэтгэлийг төлөвлөгөөтэй харьцуулбал цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчийн НДШ-ийн зардал нийт 15,752.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 51,663.8 мянган төгрөгөөр, хангамж бараа материалын зардал 3,321.3 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж 1,016.9 мянган төгрөгөөр, урсгал шилжүүлэг 2,435.8 мянган төгрөгөөр зэрэг нийт 75,237.1 мянган төгрөгөөр хэмнэгдсэн байна.

Тайлант онд сумын төсвийн хөрөнгө оруулалт, ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх нийт 12 төсөл, арга хэмжээнд 378,548.5 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 237,216.7 мянган төгрөгийн санхүүжилт олгож, 141,331.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

ХХС-аас 68,595.2 мянган төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн ч 1 иргэнд 12,000.0 мянган төгрөгийн зээл олгож, эргэж төлөгдөх зээлийг 56,595.2 мянган төгрөгөөр тус тус хэмнэснээс шалтгаалсан байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд аймгийн ЗДНХ-өөс 16,072.8 мянган төгрөг, аймгийн ОНХС-аас 360,979.2 мянган төгрөг, замын сангаас 97,808.2 мянган төгрөг, статистикийн хэлтсийн тооллогоор 6,767.4 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 21,163.8 мянган төгрөг, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 26,936.0 мянган төгрөг зэрэг нийт 529,727.4 мянган төгрөгийн эх үүсвэрийг дараах зардлуудад зарцуулсан байна. Үүнд:

- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 4,811.1 мянган төгрөг,
- Хангамж, бараа материалын зардалд 9,880.9 мянган төгрөг,
- Эд хогшил, урсгал засварын зардалд 21,166.2 мянган төгрөг,
- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжид 8,050.0 мянган төгрөг,
- Бараа үйлчилгээний бусад зардал 103,973.4 мянган төгрөг,
- Хөрөнгийн зардалд *Аймгийн ОНХО, ОНХС-ийн шилжсэн хөрөнгө оруулалтаар хийгдсэн төсөл, арга хэмжээ*/ 360,979.2 мянган төгрөг зэрэг нийт 508,860.8 мянган төгрөгийг зарцуулж, 20,866.5 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайлан, хоршоог хөгжүүлэх сан, зардлын данстай холбоотой зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Т.Болор гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Шаамар сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дүгээр сарын 03-ны өдрийн 1/44 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 5,543,609.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 55,436.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 41,577.1 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Тайлант онд хийгдсэн бүтцийн өөрчлөлтөөс шалтгаалан боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын санхүүгийн тайлан харьяа яамдад нэгтгэгдсэн тул гүйцэтгэлийн үеийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн үйл ажиллагааны зардлын 1,396,295.6 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон **13,962,9** мянган төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын 2022 оны 05 дугаар сарын 24-ний өдрийн 01/633 дугаар “Үүрэг

чиглэл өгөх тухай” албан бичгээр батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, зориулалтын дагуу зарцуулах, өр авлага үүсгэхгүй ажиллах, ТБОНӨХБАУХА тухай хууль болон босго үнийн журмыг мөрдөх, аудитаар өгөгдсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх, төсвийн хэмнэлтийн горимыг хэрэгжүүлэн ажиллахыг чиглэл болгосны дагуу дараах арга хэмжээг авч ажилласан байна. Үүнд:

- Төсвийн хэмнэлтийн горимд шилжсэнээр аймгаас өгөх санхүүгийн дэмжлэгийг 188,302.6 мянган төгрөгөөр бууруулж баталсантай холбогдуулан сум, тосгоны боловсрол, соёл, эрүүл мэндийн байгууллагуудын тогтмол зардлын санхүүжилтийг 178,352.5 мянган төгрөгөөр бууруулсан ,
- Цалин хөлс, нэмэгдэл урамшуулал, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлыг 15,752.7 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 51,663.8 мянган төгрөг, хөрөнгийн зардлыг 141,331.8 мянган төгрөг, ХХС-аас олгох зээлийг 56,595.2 мянган төгрөгөөр зэрэг нийт 273,164.1 мянган төгрөгийн төсвийн хэмнэлтийг бий болгосон байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Хүснэгт 10. Шилэн дансны цахим хуудсанд мэдээлсэн байдал

д/д	Байгууллагын нэр	Мэдээлбэл зохих	Мэдээлсэн тоо	Хугацаа хоцроосон
1	Төсвийн төвлөрүүлэн захирагч	170	125	45
2	Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	161	107	54
3	Сумын Засаг даргын Тамгын газар	161	125	36
4	Дулаанхаан тосгоны Захирагчийн алба	161	132	29
	Нийт дүн	653	489	164

Эх сурвалж: www.old.shilendans.gov.mn

Өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлэлгүйгээр тайлант хугацаанд ТТЗ, харьяа байгууллагуудын мэдээлбэл зохих 18-20 төрлийн нийт 653 мэдээллээс 489 мэдээллийг хугацаанд нь, 164 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Шийдвэрлэсэн нь: Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1-д “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.2

дахь “Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлнэ” гэж заасныг үндэслэн Шаамар сумын Санхүүгийн албаны даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Алтанчимэгт сахилгын шийтгэл ногдуулах, шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Зураг төсөв, тооцоо судалгаа нь урьдчилан хийгдээгүй 30,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “1 дүгээр багт малчдын зуслангийн шинэ худаг барих” төсөл, арга хэмжээг сумын ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэхээр ИТХ-аар батлуулж, гүйцэтгэсэн байна.

Энэ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын 4.3.3 дахь “ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь хуульд заасны дагуу зураг төсөв, техник, эдийн засгийн үндэслэлтэй, ...” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Зураг төсөв, тооцоо судалгаа нь хийгдсэн төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөж, хэрэгжүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалттай, ОНХС-аар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “ОНХС-ийн үйл ажиллагааны журам”-ын холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын 2022 оны 10 дугаар сарын 27-ны 142 дугаар “Санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” албан бичгийг хүргүүлсэн бөгөөд тус байгууллагын 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 6,788.3 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоон, 61,704.7 мянган төгрөгийн алдаа зөрчилд албан шаардлага, 455,187.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өгөгдсөнөөс 2 зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 11. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт	Биелэлт
----------	------------------------	---------

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	6	6,788.3	6	6,788.3	100.0
Албан шаардлага	10	61,704.7	10	61,704.7	100.0
Зөвлөмж	5	455,187.5	3	60,676.3	60.0
Нийт дүн	21	523,680.5	19	151,869.3	90.4

Эх сурвалж: Шаамар сумын ТТЗ-ийн 2021, 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Өмнөх аудитаар өгсөн 2 зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд зөрчлийг давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу **албан шаардлага** хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Санхүүгийн тайланд тусгагдсан 2011-2019 онуудад олгогдсон, хугацаа хэтэрсэн, /зээлийн үлдэгдлийг барагдуулахаар холбогдох шатны шүүхэд хандсан, эвлэрлийн гэрээ байгуулсан, зээл төлүүлэх мэдэгдэх хуудсыг өгч ажиллаж байгаа хэдий ч/ зээлийн үлдэгдлийг барагдуулах үр нөлөө бүхий арга хэмжээ аваагүй байна. Уг зээлийг барагдуулах талаар үр нөлөө бүхий арга хэмжээ авч, хэрэгжилтийг хангасан эсэхийг дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

2. “Дархан-Сэлэнгийн авто замаас Шаамар-Зүүнбүрэн-Цагааннуур-Түшиг-Зэлтэрийн боомт чиглэлийн 120.85 км хатуу хучилттай авто замын төсөл”-ийн гүйцэтгэгч “Монгол ЛЗ зам гүүр” ХХК-иас байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан баталгааны төлбөр болох 17,803.6 мянган төгрөгийг ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн байна. Тус компани нь нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэсэн эсэх, уг төлбөрийг хэрхэн шийдвэрлэсэн талаар дараагийн аудитаар авч үзэх шаардлагатай.

3. Аймгийн ОНХС-аас эрх шилжүүлсэн 263,179.2 мянган төгрөгийн өртөгтэй “Сумын төв доторх авто зам сайжруулахад шаардагдах цемент, материал худалдан авах” төсөл, арга хэмжээний хүрээнд худалдан авсан цемент болон бусад материалыг ашиглан ажил хийгдсэн эсэхийг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитаар авч үзэх нь зүйтэй юм.

АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 256,335.3 мянган төгрөгийн алдаа илэрснээс аудитын явцад 102,250.0 мянган төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 154,085.3 мянган төгрөгийн алдааг арилгах зөвлөмж өглөө. Үүнд:

Залруулсан алдаа:

- Аймгийн ОНХС-ийн эрх шилжсэн хөрөнгө оруулалтаар хийгдсэн **58,300.0** мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “*Шаамар сумын Дулаанхаан тосгонд бохирын машин худалдан авах*” төсөл, арга хэмжээг сумын ЗДТГ болон Дулаанхаан тосгоны Захирагчийн албаны үндсэн хөрөнгөд давхар бүртгэсэн,
- ХХААХҮЯ-аас шилжүүлэн авсан нийт **43,950.0** мянган төгрөгийн өртөгтэй 8 ширхэг хүлэмжийг санхүүгийн тайланд тусгаагүй.

Залруулаагүй алдаа:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн **128,000.0** мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “*Нийтийн ахуй үйлчилгээ, халуун усны барилга*”-ыг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Нийтийн ахуй үйлчилгээ, халуун усны барилгыг 2023 оны эхний хагас жилд багтаан санхүүгийн тайланд тусгах.

- Санхүүгийн тайланд 215,180.5 мянган төгрөгийн /зээлийн 203,060.9 мянган төгрөг, зээлийн хүүгийн 12,119.7 мянган төгрөг/ авлага тайлагнагдсан нь ХХС-ийн программаар бүртгэгдсэн 189,095.2 мянган төгрөгийн /зээлийн 175,629.3 мянган төгрөг, зээлийн хүүгийн 13,465.9 мянган төгрөг/ авлагаас **26,085.3** мянган төгрөгөөр илүү буюу авлага зөрүүтэй илэрхийлэгдсэн байна.

Өгсөн зөвлөмж: 2023 оны эхний хагас жилийн санхүүгийн тайланд авлагын зөрүүг залруулах зөвлөмж өгөв.

Аудитаар нийт 353,779.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 1,982.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 339,797.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлэн, 12,000.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж өглөө.

5.1 Төлбөрийн акт:

1. Сумын ЗДТГ-ын албан хаагчдын цалингийн нэмэгдэл, урамшууллыг **1,982.1** мянган төгрөгөөр илүү тооцож, олгосон байна. Үүнд:

- 3 албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 20-40 хувиар илүү тооцож, 552.4 мянган төгрөг илүү олгосон,
- Тооцооллын алдааны улмаас 5 албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 959.2 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон,
- Дарга Д.Энхзаяад хөдөлмөрийн аюулгүй байдлын нэмэгдлийг 470.5 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.

Эдгээр нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах*”, Нягтлан бодох бүртгэлийн

тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон нэмэгдэл цалин, урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага:

Сумын ИТХ:

1. Сумын ИТХ нь төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянан баталгаажуулаагүйн улмаас НДШ-ийн **886,8** мянган төгрөгийн авлага үүсгэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх.", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдах, төлбөр тооцоог урьдчилан хянах замаар авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

Сумын ЗДТГ:

2. Сумын ЗДТГ-ын гадна тохижилтын ажлыг гүйцэтгэж дуусаагүй, ашиглалтад хүлээн аваагүй байхад Сэврэй хайрхан групп ХХК-д **6,437.4** мянган төгрөгийг илүү шилжүүлсэн байна.

Энэ нь 2022 оны 10 дугаар сарын 04-ний өдөр байгуулсан "Ажил гүйцэтгэх гэрээ"-ний 3.1-д "ЗДТГ-ын тохижилтын ажлыг 18,500.0 мянган төгрөгөөр хийнэ. Гэрээ байгуулмагц 14 хоногийн дотор үнийн дүнгийн 60 хувийг, **ажил дуусмагц үлдэгдэл 40 хувийг шилжүүлнэ**" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Гэрээний заалтыг мөрдөж ажиллах, хүлээж авсан комиссын шийдвэрийг үндэслэн үлдэгдэл төлбөрийг шилжүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

3. МҮОНТ-ийн орон нутаг дахь сэтгүүлч Я.Наранцэцэгтэй тус телевизийн мэдээллийн цагаар мэдээлэл бэлтгэн хүргүүлэх ажлыг хийж гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулан, "Багшаа алдаршуулъя" арга хэмжээний үйл ажиллагааг нэвтрүүлсний хөлсөнд **1,600.0** мянган төгрөгийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1-д "Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно." 15.1.4-т " ... байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг,

контент, баримтат болон цуврал киноны уран бүтээл зэргийг санхүүжүүлэх” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлаас хувийн аж ахуйн нэгж Ундрагч ХХК-ийн тариан талбайд мал орохоос сэргийлж, мал хариулах гэрээний дагуу тус компанид **600.0** мянган төгрөгийг төсвөөс төлж, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “*Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

5. “Эл Эм констракшн” компанитай байгуулсан “*Машин механизм, тоног төхөөрөмж түрээслэх гэрээ*”-ний дагуу бетон зуурмаг зөөвөрлөгч миксер машиныг 2 сар ашиглуулсны төлбөрт төвлөрүүлбэл зохих **6,000.0** мянган төгрөгийг сэлбэг хэрэгсэл, засварын зардлыг уг компани барагдуулсан гэх үндэслэлээр төвлөрүүлээгүй байна.

Энэ нь “*Машин механизм, тоног төхөөрөмж түрээслэх гэрээ*”-ний 5.2-т “*Түрээсийн төлбөрийг тухай бүр бэлэн бусаар, түрээслүүлэгчийн банк дахь тооцооны 100131255001 дансанд шилжүүлэн өгнө*” гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Түрээсийн төлбөрийг гэрээний дагуу төсөвт төвлөрүүлж байх албан шаардлага хүргүүлэв.

6. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн 128,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй “*Нийтийн ахуй үйлчилгээ, халуун усны барилга*”-ыг гэрээний дагуу иргэн Б.Батсүхэд ашиглуулж, орлогыг төсөвт бус иргэнд төвлөрүүлж байгаа боловч уг барилгын ашиглалтын зардалд төсвөөс нийт **7,935.8** мянган төгрөгийг төлсөн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “*Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах*” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогыг төвлөрүүлж буй иргэнээр ашиглалтын зардлыг төлүүлэх, харилцан ашигтай гэрээ байгуулах замаар төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах албан шаардлага хүргүүлэв.

7. Сумын ИТХ, ЗДТГ нь жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй, үр дүнг шийдвэрлэж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2-т "Хөрөнгө, төлбөр тооцооны тооллогыг дараах тохиолдолд заавал хийнэ: 12.2.1: жилийн санхүүгийн тайлан гаргахын өмнө", 20 дугаар зүйлийн 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Жилийн эцсийн санхүүгийн тайлан гаргахын өмнө эд хөрөнгийн тооллого хийж, үлдэгдлийг баталгаажуулж байх албан шаардлага хүргүүлэв.

8. Анхан шатны баримтын бүрдэлгүй **120,221.8** мянган төгрөгийн ажил гүйлгээг гүйцэтгэсэн бөгөөд бараа материалын болон бэлэн мөнгөний орлого зарлагын тайланг гаргаагүй байна. Үүнд:

- Сумын ЗДТГ-ын 91,303.2 мянган төгрөгийн, ИТХ-ын 18,462.7 мянган төгрөгийн бараа материалын зарцуулалт,
- Сумын ЗДТГ-ын 10,455.9 мянган төгрөгийн бэлэн мөнгөний гүйлгээний зарцуулалт,

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4-т "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь ... хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийг тухай бүр бүртгэж байх албан шаардлага хүргүүлэв.

9. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр дараах **196,115.2** мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргасан байна. Үүнд:

- Сумын ЗДТГ нь 142,729.0 мянган төгрөгийн, ИТХ нь 6,807.3 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй,
- Сумын ЗДТГ нь 30,283.9 мянган төгрөгийн, ИТХ нь 5,108.9 мянган төгрөгийн, тосгоны Захирагчийн алба 4,307.7 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг жолоочийн тооцооны хуудсыг аргачлалын дагуу хөтлөөгүй, явах км болон 100 км-т зарцуулах жишиг нормыг зөрүүтэй тооцсон,
- Сумын ЗДТГ нь "Өмч хамгаалах байнгын зөвлөл"-өөс эдэлгээний хугацаа, уг засвар үйлчилгээг зайлшгүй хийх шаардлагатай эсэх талаар хэлэлцсэн хурлын тэмдэглэл техникийн комиссын акт, дүгнэлтгүйгээр 6,878.4 мянган төгрөгийг *лүүнээс ковш засварт 3,955.4 мянган төгрөг* албан хэрэгцээнд

ашиглаж буй тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд зарцуулсан.

Эдгээр нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм ...”, Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр “Жишиг норм батлах тухай” тушаалын 1, 5 дугаар хавсралтын холбогдох заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэв.

10. Сумын ЗДТГ-ын дарга Д.Энхзаяа, ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Дариймаа нар нь албан үүргээ хангалтгүй гүйцэтгэн, материаллаг хэмжээний зөрчил гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй, хөтөлбөр, арга хэмжээгээрх төсвийн гүйцэтгэл, нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д “Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.4 “хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга”, 54.5.5 “нэмэлт төсвийн гүйцэтгэл, түүний танилцуулга” гэж заасныг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн, үнэн зөв бэлтгэх зөвлөмж өгөв.

2. Хоршоог хөгжүүлэх сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: ХХС-аас олгох зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэх ажлын хэсэг байгуулаагүйгээс тайлант онд “Төмс хүнсний ногооны зoorь” төсөл хэрэгжүүлэгч иргэн Ж.Доржид олгосон **12,000.0** мянган төгрөгийн зээлийн барьцаа хөрөнгө нь зах зээлийн үнэлгээнд хүрсэн эсэхийг тогтоогоогүй байна.

Энэ нь ХХААХҮС-ын 2021 оны А/361 дүгээр тушаалын хавсралтаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлтэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3.4.4 дэх “Энэ журмын 3.4.3-т заасны дагуу зээлийн болон барьцааны гэрээ байгуулахдаа барьцаалах үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоох чиг үүрэг бүхий ажлын хэсэг байгуулан дүгнэлт гаргуулах бөгөөд үл хөдлөх хөрөнгийг тухайн үеийн зах зээлийн үнэлгээний 70 хүртэл хувиар үнэлэх” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ХХС-аас олгож байгаа зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээг холбогдох журмын үнэлэх ажлын хэсэг байгуулж, дүгнэлт гаргуулсны үндсэн дээр зээл олгож байх зөвлөмж өгөв.

3. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт: Сумын ИТХ-ын нарийн бичгийн даргын ЭБАТ-ны нэмэгдлийг гүйцэтгэж буй ажлын ачаалалтай уялдуулалгүйгээр хэт өндрөөр буюу 40 хувиар тооцон олгож байна.

Энэ нь аймгийн ИТХ-ын 2022 оны 208 дугаар “Сумдын ИТХ-ын дарга нарт” хүргүүлсэн албан бичгээр хүргүүлсэн “ЭБАТ-ны нэмэгдлийг аймгийн Засаг даргын захирамжийг¹ жишиг болгон мэдүүлэг гаргагчдын тоонд харгалзуулан тогтоон өгч байх” гэсэн зөвлөмжийг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: ЭБАТ-ны нэмэгдлийг мэдүүлэг гаргагчдын тоонд харгалзуулан, дээрх зөвлөмжийн дагуу тогтоон өгч байх зөвлөмж өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Аймгийн Засаг даргын 2022 оны Б/14 дүгээр “Цалингийн нэмэгдлийн хувийг шинэчлэн тогтоох тухай” захирамжийн хавсралтаар баталсан “Цалингийн нэмэгдлийн хувийг тогтоосон хүснэгт”-ийн 16-д “Шаамар сумын ЗДТГ-20%”,

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Запруулсан		Запруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
Хөрөнгө давхардуулан бүртгэсэн.	1	58,300.0			1	58,300.0						
8 ширхэг хүлэмжийг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	43,950.0	1	43,950.0			1	43,950.0				
Нийтийн ахуй үйлчилгээ, халуун усны барилгыг санхүүгийн тайланд тусгаагүй.	1	128,000.0	1	128,000.0					1	128,000.0	1	128,000.0
Санхүүгийн тайланд авлага зөрүүтэй илэрхийлэгдсэн.	1	26,085.3			1	26,085.3			1	26,085.3	1	26,085.3
Дүн	4	256,335.3	2	171,950.0	2	84,385.3	2	102,250.0	2	154,085.3	2	154,085.3

/мянган төгрөгөөр/

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Албан хаагчдын цалингийн нэмэгдэл, урамшууллыг илүү тооцож, олгосон.	1	1,982.1	1	1,982.1								

/мянган төгрөгөөр/

НДШ-ийн авлага үүсгэсэн.	1	886.8				1	886.8						
Хүлээж авсан комиссын акт, шийдвэргүйгээр гүйцэтгэгчид төлбөрийг шилжүүлсэн.	1	6,437.4				1	6,437.4						
МУОНТ-ээр арга хэмжээ нэвтрүүлсний төлбөрийг шилжүүлсэн.	1	1,600.0				1	1,600.0						
Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй.	1	600.0				1	600.0						
Гэрээний төлбөрийг төвлөрүүлээгүй байна.	1	6,000.0				1	6,000.0						
Халуун усны барилгыг иргэнд ашиглуулж, ашиглалтын зардлыг төсвөөс төлсөн байна.	1	7,935.8				1	7,935.8						
Жилийн эцэст эд хөрөнгө, бараа материалын тооллого хийгээгүй.	1	-				1	-						
Бараа материалын болон бэлэн мөнгөний орлого зарлагын тайланг гаргаагүй.	1	120,221.8				1	120,221.8						
Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй.	1	196,115.2				1	196,115.2						
Сумын ЗДТГ-ын дарга Д.Энхзаа, ИТХ-ын нарийн бичгийн дарга Б.Дариймаа нар нь албан үүргээ хангалтгүй гүйцэтгэсэн.	1	-								1	3		
Төсвийн гүйцэтгэлийн тайланг бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгээгүй.	1	-								1	-		
Хөнгөлөлттэй зээлийн барьцаа хөрөнгийг үнэлэлгүйгээр зээл олгосон.	1	12,000.0								1	12,000.0		
ЭБАТ-ны нэмэгдлийг зөрүүтэй тооцож, олгосон.	1	-								1	-		
Дүн	14	353,779.1	1	1,982.1	9	339,797.0	3	12,000.0	1	3			

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/		
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж
		Үүнээс		

	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.	164	-			164			
Дүн	164	-			164			
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Зураг төсөв, тооцоо, үнийн судалгаа нь урьдчилан хийгдээгүй төсөл, арга хэмжээг батлуулж, гүйцэтгэсэн.	1	30,000.0			1	30,000.0		
Дүн	1	30,000.0			1	30,000.0		
Нийт дүн	165	30,000.0			165	30,000.0		